



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/154

Улаанбаатар хот

Шагнах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 6-р хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид шагнал, урамшил олгох журам"-ын 2г, Байгууллагын даргын 2017 оны А/441 дүгээр тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 9.5.2, 9.16-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдах, материаллаг баазыг бэхжүүлэх, албан хаагчдын аятай тухтай ажиллах нөхцөлийг хангах үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулсныг нь үнэлж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Я.Эрдэнэсайханыг "ХҮНДЭТ ТЭМДЭГ"-ээр шагнасугай.

2. "ХҮНДЭТ ТЭМДЭГ"-т дагалдах мөнгөн шагнал 100.000 /нэг зуун мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Санхүүгийн хэлтэс /Б.Даваажав/-т зөвшөөрсүгэй.

3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /М.Төрбат/-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨРӨН

00000675